



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/153

Арвайхээр

Бүх нийтийн бэлэн байдлын улаан түвшинд  
шилжсэнтэй холбогдуулан авах зарим арга  
хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “б”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.8, 32.1.9 дэх заалт, Улсын Онцгой комиссын 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 01 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 18 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахал өвчний тархалтын түвшинд хийсэн эрсдэлийн үнэлгээтэй холбогдуулан дараах үйлчилгээний газрууд (үзвэр үйлчилгээний байгууллагууд болон олон нийтийг хамарсан хурал цуглаан, сургалт, спортын тэмцээн уралдаан, соёл урлаг, сүм хийд, кино театр, цахим болон бага насны хүүхдийн төрөл бүрийн тоглоомын газар, усан бассейн, спорт заал, хот хоорондын болон орон нутгийн нийтийн тээвэр, баар, караоке, амралт сувилал)-ын үйл ажиллагаанаас бусад зах худалдааны төв, үйлчилгээний газруудын ажиллах цагийн хуваарийг 2021 оны 04 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн 09:00 цагаас 19:00 цаг хүртэл тогтоож, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэн хяналт тавьж, цахим бүртгэлийн системийг бүрэн нэвтрүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Мөнх-Эрдэнэ), аж ахуйн нэгж байгууллагын удирдлагуудад тус тус даалгасугай

2.Иргэд олон нийтийн зүгээс халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлэхэд тэдний оролцоог сайжруулах, харьяалах нутаг, дэвсгэр, сум, баг, хороо анхан шатны нэгжид ажиллаж буй хэсгийн ахлагч нийгмийн ажилтан, олон нийтийн цагдаа нарын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэн ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Мөнх-Эрдэнэ)-т тус тус даалгасугай

3.Уул уурхайн олборлолт, зам барилга, дэд бүтэц, хөдөө аж ахуй, газар тариалангийн чиглэлийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах хүрээнд ажлын тусгай горим, халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (С.Цэдэнбалжир), холбогдох аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлагууд, сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Хаврын тариалалтын ажлыг технологийн хугацаанд үр дүнтэй зохион байгуулах, хэрэгцээт үр, бордоо, шатахуун, сэлбэг хэрэгсэл, ургамал хамгааллын бодис тээвэрлэх ажлыг саадгүй нэвтрүүлэх зорилгоор тариаланчид, ногоочид, зөгийчид, техник болон үр бордоо, ургамал хамгааллын бодис нийлүүлэгч аж ахуйн нэгжүүдийн ажилтнуудыг PCR шинжилгээг үндэслэн нийслэл, бусад аймаг, сумаас ирэх, явах ажлыг шуурхай зохион

011100332



2.

байгуулахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр), аймгийн Засаг дарын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (С.Цэдэнбалжир), сумын Засаг дарга нарт даалгасугай.

5.Халдварын эрсдэл өндөр байгаатай холбогдуулан халдварын голомт илэрсэн аж, ахуй нэгж байгууллага, төрийн байгууллагын ажилтан албан хаагчдыг 30 хүртэл хувиар ажиллуулах, бусад албан хаагчдыг ажил үүргээ зайнаас, цахимаар гүйцэтгэх нөхцөл боломжийг бүрдүүлэх, албан байгууллага бүрт халдвар хамгааллын хатуу дэглэм сахиулж, зохион байгууллалтын арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллахыг төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6.Иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлэх төрийн бүх байгууллага, хуулийн этгээд, иргэн нэг дор 5-аас дээш хүнд үйлчлэхгүй байх дэглэм, журмыг чанд мөрдүүлж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Мөнх-Эрдэнэ), төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, бизнес эрхлэгч иргэдэд тус тус үүрэг болгосугай.

7.Бүх нийтийн бэлэн байдлын улаан түвшинд байгаагаас бусад сумдын ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хичээл, сургалтын үйл ажиллагааг 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлүүлэн халдвар, хамгааллын дэглэм, холбогдох журам шийдвэрүүдийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газар (Ж.Пүрэвсүрэн), ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын эрхлэгч, сумын Засаг дарга нарт даалгасугай.

8.Арвайхээр сумыг тойрсон хяналтын цэгүүдийн үйл ажиллагааг хэвээр үргэлжлүүлж, аймгаас гарах, орох хөдөлгөөнд хяналт тавьж ажиллах, Бүрд, Бат-Өлзий, Хархорин, Хужирт сумдын хяналтын постуудыг үргэлжлүүлэн ажиллуулах, Арвайхээр сумын доторх хөдөлгөөнийг 2021 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 06:00 цагаас цуцлах арга хэмжээ авахыг холбогдох сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.


9.Банк, санхүүгийн байгууллагаар бэлэн мөнгөөр үйлчлүүлж байгаа иргэдийн хөдөлгөөнийг саармагжуулах зорилгоор иргэдийг цахим картжуулах ажлыг шуурхай зохион байгуулахыг банк, санхүүгийн байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

10.Бат-Өлзий сумыг Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахал өвчний тархалтын түвшинд хийсэн эрсдэлийн үнэлгээг үндэслэн 2021 оны 04 дүгээр сарын 02-ноос эхлэн бүх нийтийн бэлэн байдлын улаан түвшингээс өндөржүүлсэн бэлэн байдлын улбар шар түвшинд шилжүүлсүгэй

11.Аймгийн нутаг дэвсгэрт болон голомт бүхий объект, зах худалдааны төвүүдэд хуваарь гаргаж халдваргүйжүүлэлтийн ажлыг өргөн цар хүрээтэй зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), Зооноз өвчин судлалын төв (Б.Сүхбаатар), Мал эмнэлгийн газар (А.Нямдаваа)-т тус тус даалгасугай.

12.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ